



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/132

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжих нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын барилгын засварын ажлын жагсаалтыг 1 дүгээр, нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагууд, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийн жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ захирамжийн хавсралтуудад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Э.Болормаа/-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

3.Энэ захирамжийн хавсралтуудад заасан төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр нь холбогдох хууль журамд нийцсэнийг үндэслэн санхүүжүүлэх эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Н.Отгонбаяр/-т, эрх нээсний дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Б.Мөнхбат/-т, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /Ш.Үнэнбат/-т тус тус даалгасугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаад үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

111020000593

Нийслэлийн Засаг даргын 2020 оны
02 дугаар сарын 03-ны өдрийн
17/02 дугаар захирамжийн
дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ЖАГССАЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	/сая төг/	
			Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
1	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн салбар амбулаторийн барилгын их засвар /БЗД, 7 дугаар хороо/	2020	50.0	50.0
2	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн Хүүхдийн эмнэлгийн засвар /БГД, 17 дугаар хороо/	2020	30.0	30.0
3	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн амбулаторийн гадна засвар /НД, 2 дугаар хороо/	2020	40.0	40.0
4	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэс заслын тасгийн засвар /НД, 2 дугаар хороо/	2020	54.0	54.0
5	Энэрэл эмнэлгийн барилгын их засвар /БЗД, 22 дугаар хороо/	2020	50.0	50.0
6	Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын вакуум өрөөний засвар /ХУД, 4 дүгээр хороо/	2020	276.0	276.0
	ДҮН		500.0	500.0

Нийслэлийн Засаг даргын 2020 оны
02 дугаар сарын 03-ны өдрийн
А.Б.З дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУД, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВҮҮДИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ЖАГСААЛТ

					/төгрөг/
№	Тоног төхөөрөмжийн нэр	Хугацаа	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Микротом	2020	1	6,000,000	6,000,000
2	Чих хамар хоолойн иж бүрдэл	2020	2	8,000,000	16,000,000
3	Гэмтлийн жижиг мэс заслын иж бүрдэл багаж	2020	2	14,000,000	28,000,000
4	Урологийн мэс заслын иж бүрдэл багаж	2020	2	13,000,000	26,000,000
5	Бэхэлгээтэй, зогсоогч ор (bed tilt)	2020	7	4,000,000	28,000,000
6	Дасгалын ор /энгийн/	2020	7	1,200,000	8,400,000
7	Дугуй эргометр	2020	7	1,500,000	10,500,000
8	Шат	2020	5	2,000,000	10,000,000
9	Параллел бар	2020	6	1,500,000	9,000,000
10	Булчингийн хүч, сунгалт, тэсвэр сайжруулах ор бүхий иж бүрдэл	2020	7	3,000,000	21,000,000
11	Тархины харвалт болон нуруу, нугас доод мөчний гэмтлийн дараа бэхэлгээтэй алхуулагч /энгийн/	2020	7	1,350,000	9,450,000
12	Интерференциал гүйдлийн эмчилгээний аппарат	2020	6	8,000,000	48,000,000
13	Флюорография аппарат	2020	1	71,000,000	71,000,000
14	Унтуулгын аппарат	2020	4	60,000,000	240,000,000
15	Иммунологийн бүрэн автомат анализатор	2020	2	60,000,000	120,000,000
16	Хэвлийн хөндийн мэс заслын иж бүрдэл багаж /мухар олгой, цөс бусад/	2020	4	16,000,000	64,000,000
17	Шулуун гэдэсний иж бүрдэл	2020	2	8,000,000	16,000,000
18	Тарианы автомат шахуурга	2020	8	2,000,000	16,000,000
19	Дуслын автомат шахуурга	2020	4	2,000,000	8,000,000
20	Биоаюулгүйн шүүгээ	2020	1	8,000,000	8,000,000
21	Телескоф	2020	1	4,000,000	4,000,000
22	Эмгэг судлалын өрөөний хөргүүрийн төхөөрөмжүүд	2020	1	17,000,000	17,000,000
23	Физик эмчилгээний ор	2020	1	8,000,000	8,000,000
24	Өндөр давтамжит радио долгионоор түлэх эмчилгээний аппарат	2020	2	45,000,000	90,000,000
25	Хөхний биопсий вакум аппарат	2020	1	42,450,000	42,450,000
26	ЭХО аппарат /зөөврийн 4D/	2020	1	36,000,000	36,000,000
27	NEO pump	2020	1	6,000,000	6,000,000
28	Вакум татагч	2020	6	400,000	2,400,000

№	Тоног төхөөрөмжийн нэр	Хугацаа	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
29	Ларингоскоф	2020	6	400,000	2,400,000
30	Хажуугийн гэрэл	2020	2	1,000,000	2,000,000
31	Хяналтын монитор	2020	1	5,000,000	5,000,000
32	Нярайн шарлагын аппарат	2020	1	3,000,000	3,000,000
33	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	2020	4	1,900,000	7,600,000
34	Утлагын аппарат	2020	5	330,000	1,650,000
35	Судас тодруулагч	2020	1	600,000	600,000
36	Пульсоксиметр	2020	2	90,000	180,000
37	Отсос	2020	2	480,000	960,000
38	Өндөр жин хэмжигч	2020	1	320,000	320,000
39	Даралтын аппарат	2020	2	450,000	900,000
40	Окуф	2020	1	350,000	350,000
41	Эмийн тэргэнцэр	2020	2	270,000	540,000
42	Эмчилгээний тэргэнцэр	2020	1	1,800,000	1,800,000
43	Лабораторийн хөргөгч	2020	1	3,500,000	3,500,000
	ДҮН				1,000,000,000